



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/106

Цагаан-Уул сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Цагаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XIV хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/99 дүгээр захирамжийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдөр явагдах газар эзэмших цахим дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Ч.Эрдэнэчулуун (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн: Ч.Оюунчимэг (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: А.Энхбаатар (Газрын даамал)

2. Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ч.Эрдэнэчулуун)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/